


Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын хураангуй тайлан

“Бодь Даатгал” ХК

2025 оны 12 дугаар сарын 31



Хараат бус аудиторын дүгнэлт

“Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Зөрчилгүй дүгнэлт

Бид “Бодь Даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангууд (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, “Бодь Даатгал” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (СТОУС) нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Аудитын гол асуудлууд	Компани нь даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд даатгалын нөөц санг тодорхойлохдоо актуарын үлэмж тооцооллыг ашигладаг тул аудитын гол асуудал гэж үзсэн.
Материаллаг байдал	- Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал 865,064.9 мянган төгрөг ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг нийт материаллаг байдлын дүнгийн 65 хувиар буюу 562,292.2 мянган төгрөгөөр тогтоосон. - Компани нь урт хугацааны байгууллагын харилцагчдыг бий болгох зорилтыг ханган ажиллах замаар даатгалын хураамжийн орлогыг нэмэгдүүлж, зах зээлийн нэр хүнд, байр сууриа бэхжүүлэх бөгөөд татварын өмнөх ашиг нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн анхаарлыг хандуулах үзүүлэлт тул даатгалын хураамжийн нийт орлогыг материаллагийн суурь үзүүлэлтээр сонгосон.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тусдаа байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудал	Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ
Даатгалын нөөц сангийн тооцоолол Компанийн даатгалын гэрээнээс үүсэх ирээдүйн төлбөрийг хангалттай хэмжээнд бүрдүүлсэн эсэхийг үнэлэх зорилготой даатгалын нөөц сангийн тооцоолол нь санхүүгийн тайлангийн материаллаг дүн, үүргийн үнэлгээ болон компанийн төлбөрийн чадварын зохистой харьцаанд шууд нөлөөлдөг. Нөөц сангийн тооцоолол нь: - даатгалын гэрээний төрөл, нөхцөл, хугацаа, үнэлгээ, хураамж, - даатгалын тохиолдлын түүхэн өгөгдлийн үнэн зөв байдал, - актуарын аргачлал, параметрийн сонголт, - удирдлагын мэргэжлийн шүүн тунгаалт, урьдчилсан таамаглал зэрэг олон хувьсагчтай бөгөөд нарийн төвөгтэй, тодорхойгүй шинж чанартай байдаг. Иймд бид даатгалын нөөц сангийн тооцооллыг санхүүгийн тайлангийн аудитын явцад хамгийн чухал асуудлуудын нэг гэж үзэж, "Аудитын гол асуудал" болгон тодорхойлсон.	Гүйцэтгэсэн аудитын горимууд: Бид уг асуудлын хүрээнд хөндлөнгийн мэргэшсэн актуарчийн туслалцаатайгаар дараах аудитын горимуудыг гүйцэтгэв. Үүнд: - Бид Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм", ялангуяа "Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам", "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам" зэргийг үндэслэн нөөц сангийн бүрдүүлэлт, тооцооллын үндэслэл, ангилал нь шаардлагад нийцсэн эсэхийг үнэлсэн. - Бид даатгалын гэрээний төрөл, нөхцөл, хугацаа, үнэлгээ болон хураамжийн тооцоолол, нөхөн төлбөрийн түүхэн мэдээлэл, бүртгэл, ангиллын зөв байдал, тайлагнасан болон тайлагнаагүй хохирлын өгөгдөл зэргийн логик уялдаа, бүрэн байдал, үнэн зөв байдлыг шалгаж, түүхэн мэдээлэлд чанарын үнэлгээ хийсэн. - Актуарын аргачлал, таамаглалыг үнэлэхдээ хөндлөнгийн актуар мэргэжилтнийг ашиглаж актуарын аргачлалын зохистой байдал, хохирлын давтамж, дундаж хэмжээ, хөгжлийн хэв шинж, дискаунтын хувь зэрэг таамаглалуудын үндэслэл, өөрчлөлтийн логик, статистик хандлага болон түүхэн өгөгдөлтэй нийцлийг үнэлүүлсэн.

- Бид нөөц сангийн тодорхой хэсгүүдийг давтан тооцоолох, компанийн тооцоололтой харьцуулах, үүссэн зөрүү болон түүний тайлбарыг удирдлагаас авах, таамаглал болон параметрийн мэдрэмжийн шинжилгээ хийх зэрэг горимуудыг гүйцэтгэсэн.
- Санхүүгийн тайлангийн толилуулгын үнэн зөв байдлын хүрээнд нөөц сангуудын ангилал, хуваарилалт нь НББ-ийн бодлоготой нийцэж байгаа эсэх, нөөц сангийн өсөлт, бууралтын шалтгааныг тодруулгад бүрэн тусгасан эсэх, санхүүгийн тайлангийн тодруулга нь хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг бүрэн өгч буй эсэхийг үнэлсэн.

Дээр дурдсан аудитын горимуудын үр дүнд бид даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, түүний хэмжээг тодорхойлох актуарын тооцоолол нь холбогдох хууль, журам, нягтлан бодох бүртгэлийн шаардлагатай нийцэж байгаа эсэх талаар санал дүгнэлт гаргахад хангалттай аудиторын нотлох баримт цуглуулсан.

Онцлох асуудал

“Бодь Даатгал” ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 132 дугаар “Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал батлах тухай” тогтоолоор батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэж, толилуулсан.

Энэхүү заавар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчим, СТОУС нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудыг суурь болгон боловсруулагдсан бөгөөд даатгалын байгууллагуудад зориулсан журналын нийтлэг бичигтүүдийг жишээтэйгээр тусгасан байдаг.

Мөн зааварт тусгагдаагүй асуудлыг бүртгэхдээ холбогдох СТОУС нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартууд, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн баримт бичгүүд, Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журмууд, компанийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны дэлгэрэнгүй жагсаалт зэрэгт бүрэн нийцүүлэн бүртгэлийг зохион байгуулахыг шаарддаг.

Үүнтэй уялдуулан компанийн зүгээс санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ СЗХ-ноос батлан гаргасан даатгалын салбарын багц дүрэм, журам, шаардлагуудыг тууштай мөрдөж, тэдгээрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхыг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзэл хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан

гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зов толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид компанийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.


Төлбөрийн чадварын талаар

СЗХ-ны 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам"-ын 2.19-д заасны дагуу компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа **Хоёрдугаар түвшин** болох хангалттай түвшинд (2024 он: Хоёрдугаар түвшин) байгаа нь уг журмын шаардлагыг хэрэгжүүлж ажиллаж байгааг харуулж байна.

Аудитын тайлангийн хэрэглээ


Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.



О.ИДШИНРИНЖИН
УДИРДАХ ПАРТНЕР ХХК

Огноо: 2024 АНГАГАТАР ХОТ



Н.ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо:

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	264,822	748,483
Даатгалын авлага	3,588,270	3,597,009
Бусад санхүүгийн хөрөнгө	1,398,373	1,427,254
Бусад санхүүгийн бус хөрөнгө	2,508,116	1,545,826
Хөрөнгө оруулалт	26,034,352	22,442,334
Даатгалын хөрөнгө	8,638,257	8,367,884
Үндсэн хөрөнгө (цэвэр)	2,028,033	2,060,081
Биет бус хөрөнгө (цэвэр)	147,843	200,180
Ашиглах эрхтэй хөрөнгө	914,863	1,238,618
Нийт хөрөнгийн дүн	45,522,929	41,627,669
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Даатгалын өглөг	1,983,525	2,512,511
Бусад санхүүгийн өр төлбөр	884,409	525,634
Бусад санхүүгийн бус өр төлбөр	1,375,251	1,151,186
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	1,004,173	1,262,807
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	15,258,006	14,615,422
Нөхөн төлбөрийн нөөц сан	8,252,056	9,117,710
Өр төлбөрийн нийт дүн	28,757,420	29,185,270
Эздийн өмч		
Энгийн хувьцаа	5,882,975	5,882,975
Халаасны хувьцаа	(277,898)	(277,898)
Нэмж төлөгдсөн капитал	1,986,510	1,986,510
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	(135,207)	(163,652)
Хуримтлагдсан ашиг	9,309,129	5,014,464
Эздийн өмчийн дүн	16,765,509	12,442,399
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	45,522,929	41,627,669

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2025 он	2024 он
Даатгалын үйл ажиллагаа		
Даатгалын хураамжийн нийт орлого	43,253,248	32,117,857
Даатгалын хураамжийн буцаалт	(1,333,307)	(753,783)
Давхар даатгалын хураамжийн зардал	(18,459,969)	(9,192,676)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	23,459,972	22,171,398
Орлоготой тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт		
Орлоготой даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(642,584)	(2,021,728)
Орлоготой тооцсон хураамж	22,616,426	20,876,771
Нийт нөхөн төлбөрийн зардал		
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	(11,091,312)	(11,168,246)
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	3,055,256	2,402,880
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	194,754	91,050
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(7,841,302)	(8,674,316)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт		
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	(95,658)	(1,059,538)
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	370,506	614,441
Зардалд тооцсон нөхөн төлбөр	961,313	(446,284)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	(6,605,141)	(9,565,697)
Даатгалын гэрээний зардал		
Давхар даатгалын шимтгэлийн орлого	(3,293,775)	(2,922,192)
Хөрөнгө оруулалтын орлого ба олз	1,814,161	1,819,890
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	3,723,563	2,915,290
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		
Хүү, эрхийн шимтгэлийн орлого	10,828	50,292
Бусад орлого	77,845	175,683
Ерөнхий ба удирдлагын зардал	(5,675,515)	(4,869,786)
Борлуулалт, маркетингийн зардал	(4,805,142)	(4,713,422)
Санхүүгийн орлого, зардал	(229,990)	(85,252)
Бусад зардал	(1,117,726)	(645,615)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(345,399)	(22,371)
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(15,135)	(63,019)
Бусад ашиг (алдагдал)	(12,100,234)	(10,173,490)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,155,000	2,950,572

Мянган төгрөгөөр	2025 он	2024 он
Орлогын татварын зардал	(725,056)	(391,156)
Татварын дараах ашиг	5,429,944	2,559,416
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	(135,207)	(183,932)
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн	(135,207)	(183,932)
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	5,294,737	2,375,484
Нэгж хувьцаанд ногдох ашиг	0.023	0.011

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл (Дахин тайлагнасан)						
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	5,882,975	(277,898)	1,986,510	20,280	3,078,943	10,690,810
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл (Дахин тайлагнасан)						
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	2,559,416	2,559,416
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(623,895)	(623,895)
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	(165,539)	-	(165,539)
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн татварын нөлөөлөл	-	-	-	(18,393)	-	(18,393)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл						
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	5,882,975	(277,898)	1,986,510	(163,652)	5,014,464	12,442,399
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	6,098	6,098
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(1,141,377)	(1,141,377)
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	28,445	-	28,445
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл						
	5,882,975	(277,898)	1,986,510	(135,207)	9,309,128	16,766,509

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2025 он	2024 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	19,963,619	34,423,078
Даатгалын хураамжийн орлого	19,754,659	31,073,349
Давхар даатгалын нөхөн төлбөр	350	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	3,019,799
Бусад мөнгөн орлого	208,610	329,928
Мөнгөн зарлагын дүн	21,961,580	31,412,035
Ажиллагчдад төлсөн	3,445,970	2,873,359
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	509,403	842,289
Бараа материал худалдан авахад төлсөн	-	1,090
Ашиглалтын зардалд төлсөн	134,668	23,442
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	590,000	3,978,328
Нөхөн төлбөрт төлсөн	11,091,312	14,714,259
Үүнээс: Сайн дурын даатгалын	9,741,767	11,299,311
Албан журмын даатгалын	1,349,546	3,414,948
Даатгалын буцаалт, цуцлалтанд төлсөн	-	325,248
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	2,445,782	2,466,961
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	412,379	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн	11,738	37,659
Хүүний төлбөрт төлсөн	-	28,009
Татварын байгууллагад төлсөн	57,147	680,963
Даатгалын төлбөрт төлсөн	140	-
Бусад мөнгөн зарлага	3,263,041	5,440,428
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,997,961)	3,011,041
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	119,117	18,207,607
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	25,000	325,510
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	17,831,592
Хүлээн авсан хүүний орлого	94,117	50,505
Мөнгөн зарлагын дүн	-	19,174,500
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	8,500
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	19,166,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	119,117	(966,893)

Мөнгөн гүйлгээний тайлан

(үргэлжлэл. . .)

Мянган төгрөгөөр	2025 он	2024 он
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,600,371	2,618,837
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,357	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,595,014	2,618,837
Бусад	1,000	-
Мөнгөн зарлагын дүн	205,188	4,157,842
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,489	3,148,752
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	101,000	-
Төлсөн ногдол ашиг	-	1,009,090
Бусад	100,699	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,395,183	(1,539,005)
Валютын ханшийн зөрүү	-	(4,037)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(483,661)	501,106
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	748,483	247,377
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	264,822	748,483